



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 328

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхөөгүй боловч цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 28,978,000.00 (хорин найман сая есөн зуун далан найман мянган) төгрөгийн балансын үнэ, 25,974,466.94 (хорин төвөн сая есөн зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун жаран зургаан төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;


2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу няглан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

000211-

Төрийн өмчийн бодлогоо, зохицуулалтын газрын  
2018 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн  
320 дугаар тогтоолын хавсралт

"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчтэй хувьцаат компанийн  
ундсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаах автомашинны жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориуулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн/ ashiiglal тад орсон он	Нийт гүйлт /км/ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/	Хуриимтлагдсан элэгдэл /төгрөг/ /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/ /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/ /төгрөг/
1	"Форд транзит", тусгай, 44-65 УНЕ, ХЕ26772, BDVAXE26772	1999/2011	194920	7,000,000.00	3,996,466.94	3,003,533.06	0	3,500,000.00
2	"Ландкруйзер-80", суудлын, 56-30 УНЗ, HDJ810047067	1994/2007	221899	21,978,000.00	21,978,000.00	0	0	4,000,000.00
					25,974,466.94 (хорин төвөн сая есөн зуун далан дөрвөн мянга дөрвөн далан найман зуун жаран мянган)	3,003,533.06 (гурван сая гурван мяняга таван зуун гучин гурван төгрөг зургаан мөнгө)	-	7,500,000.00 (доллоон сая таван зуун мянган)
					Нийт дүн			